

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/117/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Авирмэд

Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. Аудитын илрүүлэлт	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.16 № УВА-2023/117/НА-СТА-ТЦЦЗ

танай _____-ны № _____-т

УЛААНГОМ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 5 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.БАДРАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Монгол улсын нийт Ерөнхий боловсролын сургуулиудын дунд зарласан "Олимпын боловсрол ба бие бялдрын хүмүүжил" болзолт уралдаанд оролцож улсын хэмжээний шилдэг 30 сургуулийн нэгээр шалгарсан.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>103,146,057.86</u>	<u>128,887,271.32</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	8,941,517.42
312	Банканд байгаа бэлэн мөнгө	00.00	8,941,517.42
3121	Төгрөг	00.00	8,941,517.42
31211	Төрийн сангийн харилцах	00.00	8,941,517.42
35	БАРАА МАТЕРИАЛ	103,146,057.86	119,945,753.90
351	Түүхий эд материал	8,377,322.86	9,678,355.30
35110	Тусгай зориулалттай материал	7,897,022.86	9,191,400.30
35130	Эм боох материал	480,300.00	486,955.00
354	Хангамжийн материал	94,768,735.00	110,267,398.60
35420	Аж ахуйн материал	16,196,200.00	30,227,153.60
35440	Түлш, шатах тослох материал	847,000.00	847,000.00
35460	Хүнсний материал	1,157,790.00	2,625,500.00
35470	Бусад хангамжийн материал	76,567,745.00	76,567,745.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,849,537,677.40</u>	<u>3,859,046,567.37</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,849,537,677.40	3,859,046,567.37
392	Биет хөрөнгө	3,404,110,566.40	3,414,230,567.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,738,231,250.00	3,875,829,393.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-478,426,725.40	-621,236,306.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	219,259,321.00	267,734,321.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-145,759,912.44	-172,681,314.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	109,180,555.90	112,516,555.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-71,798,914.54	-87,559,836.86
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,208,500.00	7,708,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,208,500.00	-3,583,500.02
39217	Ном	33,424,991.88	35,502,754.72
393	Биет бус хөрөнгө	444,816,111.00	444,816,000.00
39301	Программ хангамж	3,285,000.00	3,285,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,673,889.00	-3,285,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	444,816,000.00	444,816,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,952,683,735.26</u>	<u>3,987,933,838.69</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,952,683,735.26</u>	<u>3,987,933,838.69</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,952,683,735.26	3,987,933,838.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	955,381,964.11	955,381,964.11
51101	Өмч: - төрийн	955,381,964.11	955,381,964.11
512	Хуримтлагдсан үр дүн	2,787,724,234.69	2,822,974,338.12
51210	Өмнөх үеийн үр дүн	2,787,724,234.69	2,787,724,234.69
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	35,250,103.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	209,577,536.46	209,577,536.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,952,683,735.26</u>	<u>3,987,933,838.69</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,102,799,878.88	1,593,110,375.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,097,924,453.88	1,586,256,175.28
120	Нийтлэг татварын бус орлого	1,890,430.88	183,343,275.28
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,710,030.88	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,710,030.88	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,096,034,023.00	1,402,912,900.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	933,742,300.00	1,187,576,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,875,425.00	6,854,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,875,425.00	6,854,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,650,000.00	2,550,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	225,425.00	2,004,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,289,974,225.17	1,557,860,271.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,289,974,225.17	1,557,860,271.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,257,064,024.17	1,508,465,437.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	751,921,057.00	935,617,240.00
210101	Үндсэн цалин	538,274,582.00	706,312,803.00
210102	Нэмэгдэл	162,478,700.00	189,305,070.00
210104	Урамшуулал	51,167,775.00	39,999,367.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,999,088.00	116,307,676.07
210201	Тэтгэврийн даатгал	70,332,888.00	79,123,382.02
210202	Тэтгэмжийн даатгал	7,416,400.00	9,308,591.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,933,100.00	7,446,852.82
210204	Ажилгүйдлийн даатгал	1,483,500.00	1,857,177.28
210205	Эрүүл мэндийн даатгал	14,833,200.00	18,571,672.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	158,476,023.00	150,515,697.00
210301	Гэрэл, цахилгаан	15,082,897.00	11,260,193.00
210302	Түлш, халаалт	141,446,126.00	135,262,504.00
210303	Цэвэр, бохир ус	1,947,000.00	3,993,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,257,629.00	5,567,908.40
210401	Бичиг хэрэг	1,216,625.00	198,500.00
210402	Тээвэр, шатахуун	563,380.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	828,324.00	386,105.00
210404	Ном, хэвлэл	33,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,271,000.00	1,547,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,345,000.00	3,435,703.40
2105	Нормативт зардал	34,338,330.00	67,801,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	172,700.00	376,360.00

210502	Хоол, хүнс	33,525,630.00	67,424,690.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	640,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,319,400.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	10,319,400.00	8,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,144,400.00	9,132,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,040,300.00	2,004,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,954,100.00	7,072,900.00
210807	Газрын төлбөр	150,000.00	55,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	188,608,097.17	215,523,765.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	18,736,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,769,150.00	10,809,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	185,838,947.17	185,978,015.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,910,201.00	49,394,834.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,893,400.00	43,824,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,307,400.00	43,824,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,586,000.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,016,801.00	5,570,234.51
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,016,801.00	5,570,234.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-187,174,346.29	35,250,103.43
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-187,174,346.29	35,250,103.43

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,100,909,448.00	1,409,767,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,096,034,023.00	1,402,912,900.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,096,034,023.00	1,402,912,900.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	933,742,300.00	1,187,576,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,875,425.00	6,854,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,875,425.00	6,854,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,650,000.00	2,550,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	225,425.00	2,004,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,100,909,448.00	1,400,825,582.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,100,909,448.00	1,400,825,582.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,067,999,247.00	1,351,430,748.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	751,921,057.00	935,617,240.00
210101	Үндсэн цалин	538,274,582.00	706,312,803.00
210102	Нэмэгдэл	162,478,700.00	189,305,070.00

210104	Урамшуулал	51,167,775.00	39,999,367.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,999,088.00	116,307,676.07
210201	Тэтгэврийн даатгал	70,332,888.00	79,123,382.02
210202	Тэтгэмжийн даатгал	7,416,400.00	9,308,591.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,933,100.00	7,446,852.82
210204	Ажилгүйдлийн даатгал	1,483,500.00	1,857,177.28
210205	Эрүүл мэндийн даатгал	14,833,200.00	18,571,672.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	151,972,323.00	150,515,697.00
210301	Гэрэл, цахилгаан	15,082,897.00	11,260,193.00
210302	Түлш, халаалт	134,942,426.00	135,262,504.00
210303	Цэвэр, бохир ус	1,947,000.00	3,993,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,236,429.00	00.00
210401	Бичиг хэрэг	1,040,425.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	563,380.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	828,324.00	00.00
210404	Ном, хэвлэл	266,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,650,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,888,000.00	00.00
2105	Нормативт зардал	35,821,300.00	68,892,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	370,300.00	00.00
210502	Хоол, хүнс	33,461,000.00	68,892,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,990,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,079,300.00	8,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,759,900.00	00.00
210604	Урсгал засвар	10,319,400.00	8,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,144,400.00	9,098,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,040,300.00	2,004,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,954,100.00	7,094,680.00
210807	Газрын төлбөр	150,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,825,350.00	62,998,855.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	52,189,805.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,825,350.00	10,809,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,910,201.00	49,394,834.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,893,400.00	43,824,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,307,400.00	43,824,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,586,000.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,016,801.00	5,570,234.51
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,016,801.00	5,570,234.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	8,941,517.42
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	8,941,517.42
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	8,941,517.42

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	510,565,964.11	00.00	2,914,471,852.49	3,425,037,816.60
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	510,565,964.11	00.00	2,914,471,852.49	3,425,037,816.60
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	444,816,000.00	00.00	-17,817,703.39	426,998,296.61
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	955,381,964.11	209,577,536.46	2,787,724,234.69	3,952,683,735.26
D01	2022 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	955,381,964.11	209,577,536.46	2,787,724,234.69	3,952,683,735.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	955,381,964.11	209,577,536.46	2,787,724,234.69	3,952,683,735.26
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	35,250,103.43	35,250,103.43
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	955,381,964.11	209,577,536.46	2,822,974,338.12	3,987,933,838.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,412,517,100.00	1,395,255,348.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,412,517,100.00	1,395,255,348.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,368,441,500.00	1,351,430,748.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	935,793,700.00	935,617,240.00
210101	Үндсэн цалин	749,206,700.00	706,312,803.00
210102	Нэмэгдэл	166,211,400.00	189,305,070.00
210104	Урамшуулал	20,375,600.00	39,999,367.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,924,200.00	116,307,676.07
210201	Тэтгэврийн даатгал	79,542,600.00	79,123,382.02
210202	Тэтгэмжийн даатгал	9,357,900.00	9,308,591.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,486,300.00	7,446,852.82
210204	Ажилгүйдлийн даатгал	1,867,000.00	1,857,177.28
210205	Эрүүл мэндийн даатгал	18,670,400.00	18,571,672.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	156,085,700.00	150,515,697.00
210301	Гэрэл, цахилгаан	14,650,000.00	11,260,193.00
210302	Түлш, халаалт	135,262,500.00	135,262,504.00
210303	Цэвэр, бохир ус	6,173,200.00	3,993,000.00
2105	Нормативт зардал	73,620,700.00	68,892,400.00
210502	Хоол, хүнс	73,620,700.00	68,892,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	8,000,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,211,500.00	9,098,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,004,200.00	2,004,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,207,300.00	7,094,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68805700.00	62998855.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,994,800.00	52,189,805.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,810,900.00	10,809,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44075600.00	43824600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,075,600.00	43,824,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44,075,600.00	43,824,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,412,517,100.00	1,404,196,865.49
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,402,912,900.00	1,397,342,665.49
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,187,576,900.00	1,187,576,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	215,336,000.00	209,765,765.49
132001	Орон нутгийн төсвөөс	215,336,000.00	209,765,765.49
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,754,200.00	2,004,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,850,000.00	4,850,000.00

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	8,941,517.42
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	65.00	65.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	45.00	45.00
620003	Үйлчлэх ажилтан	19.00	19.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	321.00	443.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	320.00	442.00
630001	Төрийн өмчит ЕБС	320.00	442.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	01.00	01.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	01.00	01.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	65.00	65.00
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	41.00	41.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	24.00	24.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь иргэдэд бүх нийтийн ерөнхий боловсролын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй ба “Цэгцтэй мэдлэг Цэвэр орчин” гэсэн зорилгын дор 2022 онд “Эрүүл чийрэг, зөв хандлагатай, бүтээлч, хүмүүнлэг иргэнийг төлөвшүүлэх” гэсэн зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,250.1 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	8,941.5	8,941.5
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	103,146.1	119,945.7	16,799.7
Үндсэн хөрөнгө	3,849,537.6	3,859,046.5	9,508.9
Нийт хөрөнгө	3,952,683.7	3,987,933.8	35,250.1
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,952,683.7	3,987,933.8	35,250.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,952,683.7	3,987,933.8	35,250.1

Мөнгөн хөрөнгийн данс 8,941.5 төгрөгийн үлдэгдэл болсон нь улсын төсвийн санхүүжилтийн үлдэгдлээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 119,945.7 мянган төгрөг болж 16,799.7 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоос шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,987,933.8 мянган төгрөг болж 9,508.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр болон үнэ төлбөргүй хүлээн авсан орлого барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ном нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,987,933.8 мянган төгрөг болж 35,250.1 мянган төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,466,033.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,466,033.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 65,965.3 мянган төгрөгөөр бууруулж 1,400,068.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалингийн зардлын санхүүжилт буурч ирсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,412,517.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,187,576.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, нэмэлт санхүүжилтээр 9,604.2 мянган төгрөг, 215,336.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,187,576.9 мянга, орон нутгийн төсвөөс 215,336.0 мянга, нэмэлт санхүүжилтээр 6,854.2 мянган төгрөг нийт 1,409,767.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,400,825.6 мянган төгрөгийг зарцуулж, 8,941.5 мянган төгрөгийг үлдэгдэлтэй гарч, 5,570.3 төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,400,825,6 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь зардлыг 14,511.8 мянган төгрөгөөр хэмнэж 2,750.0 мянган төгрөгийн санхүүжилт дутуу ирсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Ерөнхий боловсрол, төрийн өмчийн барилгын тогтмол зардал	156,085.7	150,515.7	5,570.0	96.4%
2	Ерөнхий боловсрол, нийтлэг үйлчилгээ	51,250.3	51,250.1	0.2	100%
3	Ерөнхий боловсрол, байр ашиглалтын үйлчилгээ	2,882.9	2,881.6	1.3	100%
4	Ерөнхий боловсрол, сургалт семинар	1,441.5	1,440.0	1.5	99.9%
5	Ерөнхий боловсрол, эрүүл мэндийг дэмжих	3,315.3	3,315.0	0.3	100%
6	Ерөнхий боловсрол, Үдийн цай хөтөлбөр	44,075.6	43,824.6	251.0	99.4%
7	Ерөнхий боловсрол, Дотуур байрны үйлчилгээ	91,280.8	86,551.9	4,728.9	94.8%
8	Ерөнхий боловсрол, Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	29,970.0	26,970.0	3,000.0	90%
9	Ерөнхий боловсрол, Боловсролыг байгууллагын багш	6,486.5	6,486.3	0.2	100%
10	Ерөнхий боловсрол, Боловсролыг стандарт	842,245.3	842,064.7	180.6	99.9%
11	Ерөнхий боловсрол, Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	165,879.0	165,101.3	777.7	99.5%
12	Ерөнхий боловсрол, Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	1,750.0	0	1,750.0	0
13	Ерөнхий боловсрол, Сурах бичгийн түрээс	2,004.2	2,004.2	0	100%
14	Ерөнхий боловсрол, ЗГ болон ЗД-ийн нөөц хөрөнгөөс хуваарилсан	3,300.0	2,300.0	1,000.0	69.7%
15	Ерөнхий боловсрол, Нэмэлт шатны төсвөөс хуваарилсан	2,550.0	2,550.0	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2,550.0 мянга, Төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,300.0 мянган төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,004.2 мянга нийт 6,854.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэрэг хичээлийн хэрэглэгдэхүүний болон сургалтын зардалд 4,850.0 мянга, сурах бичгийн түрээсийн төлбөрт 2,004.2 мянга, нийт 6,854.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 10.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,557.8 сая төгрөгийн хувь буюу 15.5 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 12.4 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 142, хугацаа хоцроож байршуулсан 5, байршуулаагүй 2, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь 170,848.4 мянган төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроосон, 32,558.9 мянган төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй зөрчилд зөвлөмж өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлэн ажилласан байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3,706.0	1	3,706.0	100
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн	1	3,706.0	1	3,706.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,389.8 мянган төгрөгийн 4 зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сургуулийн захирал Б.Бадрал эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр өөртөө шийдвэр гаргаж 2022 оны А/47 дугаар тушаалаар 1,050.0 мянган төгрөгийн нөхөх төлбөр авсан. Мөн албан хаагчдад нөхөх төлбөр олгоходоо 11 албан хаагчдад /захирлын зөвлөлийн гишүүд/ бусад албан хаагчдаас тус бүр 420.0 мянга нийт 4,620.0 мянган төгрөг илүү олгож тэгш бус байдал үүсгэсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь хэсэгт “Албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах” гэж заасныг тус тус мөрдөж ажиллах.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын батлагдсан орон тоонд байхгүй төрийн албаны хүний нөөцийн цахим системийн ажлыг бичиг хэргийн ажилтан Б.Бурмааг хавсран ажиллуулах сургуулийн захирлын 2022 оны Б/09 дүгээр тушаал гаргаж нэмэгдэл олгосон байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Төсвийн тухай хуулийн 16.5.3-д “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасныг мөрдөж ажиллах.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Танхимаас гадуурх хичээл сургалтын үйл ажиллагааны зардлаас 1,440.0 мянган төгрөгийг нийгмийн ажилтан Д.Дэлгэрхишигийн дансаар дамжуулан гаргаж зориулалт бусаар зарцуулсан байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэгт “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг мөрдөж ажиллах.

4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Улаангом сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь 170,848.4 мянган төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроосон, 32,558.9 мянган төгрөгийн 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэн ажиллах.

5. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах зорилгоор Цагаанчулуут Увс ХХК шилжүүлсэн 1,990.0 мянга, сургалтад хамруулахаар нийгмийн ажилтан Д.Дэлгэрхишигт олгосон 350.0 мянга, нийт 2,340.0 мянган төгрөгийн зарцуулалтын тайлан байхгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хууль тогтоомж зөрчиж нөхөх төлбөр олгосон. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, зарцуулалтын тайлан байхгүй	4	10,389.8					4	10,389.8				
Дүн	4	10,389.8					4	10,389.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудаст мэдээлэл, байршуулаагүй хугацаа хоцроож мэдээлсэн.	1	203,407.3					1	203,407.3
Дүн	1	203,407.3					1	203,407.3
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	203,407.3					1	203,407.3

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТООУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/Б.АВИРМЭД/

2023 оны 02 сарын 16-ны өдөр